



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/107НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт	11
4.1 Зөвлөмж	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/101

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

005020478

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,799,800.00	7,020,436.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,799,800.00	7,020,436.00
354	Хангамжийн материал	3,799,800.00	7,020,436.00
35410	Бичиг хэргийн материал	872,000.00	1,416,700.00
35420	Аж ахуйн материал	2,927,800.00	4,930,440.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	673,296.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,408,172.58	17,173,594.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,408,172.58	17,173,594.62
392	Биет хөрөнгө	9,408,172.58	17,173,594.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,991,319.50	10,991,319.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,991,319.50	-10,991,319.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,964,720.00	33,711,720.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,025,170.00	-24,120,020.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,239,820.00	16,619,820.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,821,097.42	-9,087,825.38
39217	Ном	49,900.00	49,900.00
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-880,000.00	-880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,207,972.58	24,194,030.62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,207,972.58	24,194,030.62
51	Засгийн газрын хувь оролцоо	13,207,972.58	24,194,030.62
512	Хуримтлагдсан үр дүн	13,207,972.58	24,194,030.62
51210	Өмнөх үеийн үр дүн	5,819,246.45	13,207,972.58
51220	Тайланг үеийн үр дүн	7,388,726.13	10,986,058.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,207,972.58	24,194,030.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	170,493,900.00	194,553,326.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,602,500.00	673,726.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,602,500.00	673,726.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,602,500.00	673,726.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,602,500.00	673,726.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	161,891,400.00	193,879,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	156,891,400.00	193,879,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	156,891,400.00	193,879,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	163,105,173.87	183,567,267.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	163,105,173.87	183,567,267.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	156,012,210.31	181,789,911.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	114,766,809.44	129,679,425.28
210101	Үндсэн цалин	100,516,009.44	118,644,425.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,057,565.00	11,035,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,193,235.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,447,200.00	16,826,151.35
210201	Тэтгэврийн даатгал	9,824,100.00	11,562,918.75
210202	Тэтгэмжийн даатгал	1,155,800.00	1,342,400.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	924,600.00	1,038,181.56
210204	Ажилгүйдлийн даатгал	231,200.00	251,887.83
210205	Эрүүл мэндийн даатгал	2,311,500.00	2,630,763.14

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2104	Хангамж, бараа материалын зардал	11,065,335.00	12,061,665.00
210401	Бичиг хэрэг	2,836,340.00	2,507,200.00
210402	Тээвэр, шатахуун	7,009,600.00	8,002,030.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,219,395.00	758,375.00
210404	Ном, хэвлэл	00.00	330,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	463,660.00
2105	Нормативт зардал	200,000.00	200,000.00
210502	Хоол, хүнс	200,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,874,000.00	7,180,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,874,000.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	7,180,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,410,000.00	8,389,000.00
210702	Дотоод албан томилолт	8,410,000.00	8,389,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	681,592.00	839,092.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	382,500.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	149,092.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,000.00	172,092.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	245,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,567,273.87	6,614,577.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	844,500.00	1,253,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,722,773.87	5,361,577.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,092,963.56	1,777,356.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,913,750.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,913,750.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	179,213.56	277,356.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	179,213.56	277,356.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,388,726.13	10,986,058.04
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	7,388,726.13	10,986,058.04

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	161,891,400.00	193,879,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	161,891,400.00	193,879,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	156,891,400.00	193,879,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	156,891,400.00	193,879,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	160,491,400.00	181,132,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	160,491,400.00	181,132,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	153,398,436.44	179,355,243.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	114,626,809.44	129,679,425.28
210101	Үндсэн цалин	100,376,009.44	118,644,425.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,057,565.00	11,035,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,193,235.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,447,200.00	16,826,151.35
210201	Тэтгэврийн даатгал	9,824,100.00	11,562,918.75
210202	Тэтгэмжийн даатгал	1,155,800.00	1,342,400.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	924,600.00	1,038,181.56
210204	Ажилгүйдлийн даатгал	231,200.00	251,887.83
210205	Эрүүл мэндийн даатгал	2,311,500.00	2,630,763.14
2104	Хангамж, бараа материалын зардал	10,804,335.00	14,773,575.00
210401	Бичиг хэрэг	2,101,210.00	2,836,900.00
210402	Тээвэр, шатахуун	7,009,600.00	8,381,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,502,395.00	758,375.00
210404	Ном, хэвлэл	191,130.00	1,997,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	799,700.00

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2105	Нормативт зардал	1,200,000.00	200,000.00
210502	Хоол, хүнс	200,000.00	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,874,000.00	7,180,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,874,000.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	7,180,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,410,000.00	8,389,000.00
210702	Дотоод албан томилолт	8,410,000.00	8,389,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	681,592.00	1,054,092.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	382,500.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	149,092.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,000.00	172,092.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	460,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,354,500.00	1,253,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,354,500.00	1,253,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,092,963.56	1,777,356.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,913,750.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,913,750.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	179,213.56	277,356.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	179,213.56	277,356.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,400,000.00	12,747,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,400,000.00	12,747,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,400,000.00	12,747,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,400,000.00	12,747,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,400,000.00	12,747,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,400,000.00	-12,747,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр /
						Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	5,819,246.45	00.00	5,819,246.45
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-10,138,832.10	00.00	-10,138,832.10
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	-4,319,585.65	00.00	-4,319,585.65
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	7,388,726.13	00.00	7,388,726.13
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	13,207,972.58	00.00	13,207,972.58
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	13,207,972.58	00.00	13,207,972.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	13,207,972.58	00.00	13,207,972.58
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,986,058.04	00.00	10,986,058.04
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	24,194,030.62	00.00	24,194,030.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/ төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	193,879,600.00	193,602,243.63	277,356.37	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	193,879,600.00	193,602,243.63	277,356.37	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	192,379,600.00	192,102,243.63	277,356.37	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	129,830,000.00	129,679,425.28	150,574.72	99.9
210101	Үндсэн цалин	118,765,000.00	118,774,425.28	-9,425.28	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,065,000.00	10,905,000.00	160,000.00	98.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,922,600.00	16,826,151.35	96,448.65	99.4
210201	Тэтгэврийн даатгал	11,568,700.00	11,562,918.75	5,781.25	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,353,400.00	1,342,400.07	10,999.93	99.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,082,700.00	1,038,181.56	44,518.44	95.9
210204	Ажилгүйдлийн даатгал	264,900.00	251,887.83	13,012.17	95.1
210205	Эрүүл мэндийн даатгал	2,652,900.00	2,630,763.14	22,136.86	99.2
2104	Хангамж, бараа материалын зардал	14,800,300.00	14,773,575.00	26,725.00	99.8
210401	Бичиг хэрэг	2,837,100.00	2,836,900.00	200.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	8,381,600.00	8,381,600.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	781,600.00	758,375.00	23,225.00	97.0
210404	Ном, хэвлэл	2,000,000.00	1,997,000.00	3,000.00	99.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	799,700.00	300.00	100.0
210502	Хоол, хүнс	200,000.00	200,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,927,000.00	19,927,000.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,747,000.00	6,747,000.00	0.00	100.0
210602	Тавилга	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	7,180,000.00	7,180,000.00	0.00	100.0
2107	Томилголт, зочны зардал	8,392,600.00	8,389,000.00	3,600.00	100.0
210702	Дотоод албан томилолт	8,392,600.00	8,389,000.00	3,600.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,054,100.00	1,054,092.00	8.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	150,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	172,100.00	172,092.00	8.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	460,000.00	460,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,253,000.00	1,253,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,253,000.00	1,253,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	193,879,600.00	193,602,243.63	277,356.37	99.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	193,879,600.00	193,602,243.63	277,356.37	99.9
132001	Орон нутгийн төсвөөс	193,879,600.00	193,602,243.63	277,356.37	99.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	09.00	09.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	07.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620004	Гэрээг ажилтан	02.00	02.00	00.00	100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын төсвийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг дарга Д.Даваажаргал, 2 дугаар гарын үсгийг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын нягтлан бодогч Д.Мөнхтуяа нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрсдэлд суурилсан дотоод аудит, хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэргэжил арга зүй, зөвлөгөө өгөх замаар төсвийн сахилга батыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, хараат бус бие даасан, бодитой баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сангийн яамны дотоод аудитын хэлтэс нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 163,105.2 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 3,262.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,283.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 3,671.3 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,986.1 мянган төгрөгөөр буюу 83.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,799.8	7,020.4	3,220.6
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	3,799.8	7,020.4	3,220.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,408.2	17,173.6	7,765.4
Үндсэн хөрөнгө	49,125.8	62,252.8	13,127.0
Хуримтлагдсан элэгдэл	(39,717.6)	(45,079.2)	(5,361.6)
Нийт хөрөнгө	13,208.0	24,194.0	10,986.1
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	13,208.0	24,194.0	10,986.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	13,208.0	24,194.0	10,986.1

Бараа материалын дансны үлдэгдэл 7,020.4 мянган төгрөг болж 3,220.6 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг, аж ахуй, түл, шатах тослох материал дансны үлдэгдэл өмнөх оноос 3,220.6 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 62,252.8 мянган төгрөг болж 13,127.0 мянган төгрөгөөр өссөн нь 6,747.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 6,380.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил төсвийн хөрөнгөөр худалдан авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 21,194.0 мянган төгрөг болж 10,986.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 10,986.1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 266,662.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 266,662.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 90,212.7 мянган төгрөгөөр бууруулж 176,449.6 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг улсын төсвийн 193,879.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 193,879.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 193,602.2 мянган төгрөгийг зарцуулж 277.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 193,602.5 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 247.0 мянга, хангамж бараа материалын зардлыг 26.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Тус байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 10 зорилтын хүрээнд 53 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 100 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 183,567.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 20,462.1 мянган төгрөгөөр буюу 12.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж

бараа материалын зардал, дотоод албан томилолтын зардал, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 204,379.6 мянган төгрөгийн 27 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой 16,332.1 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд урсгал төсвийн зарцуулалт нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 11,093.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,500.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 9,593.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах нэг зөвлөмж хүргүүлээ.

4.1 Зөвлөмж

Тус байгууллага нь 2021 онд нийт 204,379.6 мянган төгрөгийн 27 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой 16,332.1 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба										1	-

_____оОо_____